

МОНГОЛ ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН "УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ"
НИЙГЭМЛЭГИЙН
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ
ТАРБЫН ГАЗАР

2017 08 02

№ 292

Маягт өөрчилж, мөрдүүлэх тухай

Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн дүрмийн 22 дугаар зүйлийн "а" заалтыг үндэслэн ачаа тээврийн анхан шатны бүртгэлийг цэгцлэх, давхар хөтлөгдөж буй дэвтрийн хөтлөлтийг нэгтгэх, үзлэгийн чанарыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь.

Нэг ГУ-98А, ГУ-98Б дэвтрүүдэд зохих өөрчлөлтийг хийж, замын хэмжээнд ачилт, /буулгалт/-ын вагон чингэлгийн ачаа тээврийн үзлэгт бэлтгэх дэвтэр маягт ГУ-98А-г нэгдүгээр хавсралтаар, ачааны галт тэргэнд ачаа тээврийн үзлэг хийж бүртгэх дэвтэр маягт ГУ98Б-г хоёрдугаар хавсралтаар, галт тэрэгний үзлэгийн дэвтэр ВУ-14-г гуравдугаар хавсралтаар, дэвтэр маягтыг хөтлөх зааврыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай

Хоёр 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ГУ-98А, ГУ-98Б дэвтрүүдийг Тээвэр зохион байгуулалтын албаны хэмжээнд мөрдөж ажилласугай

Гурав Энэ тушаал гарсантай холбогдуулан УБТЗ-ын даргын 2006 оны 01 дүгээр сарын 18-ны А-15 тоот тушаалын 3, 4 дүгээр хавсралт, 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-219 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай

Дөрөв Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тээвэрлэлт хөдөлгөөн хариуцсан замын орлогч дарга /Л Халтар/-д үүрэг болгосугай

ДАРГА

Д ЖИГЖИДНЯМАА

Ачилт /буулгалт/-ын вагон, чингэлэгийг ачаа тээврийн
үзлэгт бэлтгэх дэвтэр МАЯГТ 98А

Вагон үзэгчийн нэр

[illegible]

Ачааны вагоны техник үзлэгийн дэвтэр Маягт-14

Ахлах үзэгч

[illegible]

УБТЗ-ын даргын 2017 оны 08 дугаар
сарын 02-ны өдрийн 4-242 тоот
тушаалын дөрөвдүгээр хавсралт

ГУ-98А, ГУ-98Б, ВУ-14 дэвтэрт маягтыг хөтлөх заавар


Нэг Ачилтанд вагон чингэлэг үзлэгт оруулах дэвтэрт маягт ГУ-98А /хавсралт №1/-ийн 1-7, 9-14 дүгээр хүснэгтүүдийг ачаа тээврийн ажилтан, 8,12,13,14 дугаар хүснэгтүүдийг техник үзлэгийн газрын ажилтан тус тус хөтөлж 15-р хүснэгтэнд ээлжийн ахлагч /ДСП, ДСПП, ДСЦг / гарын үсэг зурна. Өртөөний болон салбар замд вагон, чингэлэг ачилтанд бэлтгэн үзүүлэх тохиолдолд ажилтаны аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар технологийн процесст тусгасан байна.

Хоёр Ачааны галт тэргэнд ачаа тээврийн үзлэг хийж бүртгэх дэвтэр маягт ГУ-98 Б / хавсралт №2 /-ийн 1-6, 8-12 дугаар хүснэгтүүдийг технологийн процесст заагдсан өртөөний ажилтан бөглөж 7,13-р хүснэгтүүдэд ээлжийн ахлагч / ДСП, ДСПП/ гарын үсэг зурна.


Гурав Ачааны вагоны техник үзлэгийн дэвтэр маягт ВУ-14 /хавсралт №3/-ийн 1-8 дугаар хүснэгтийг технологийн процесст заагдсан өртөөний ажилтан, 8-13 дугаар хүснэгтүүдийг техник үзлэгийн газрын ажилтан " ахлах үзэгч, үзэгч" тус тус хөтөлж 14-р хүснэгтэнд ээлжийн ахлагч гарын үсэг зурна.

Боловсруулсан КР-2  Ц Төгсжаргал

Зөвшөөрсөн.

ДКР  Ж.Шагдарсүрэн

ДР  А Бор-банди

ВР/  А Пүрэвбаатар